

Монголын хүн амын ядуурал ба амьжиргааны байдал

Б. Энхцэцэг

**Монгол Улсын Их Сургууль,
Хүн Ам Зүйн Сургалт Судалгааны Төв,
эрдэм шинжилгээний ажилтан**

Хүн төрөлхтний хөгжлийн урт удаан хугацаанд тэднийг сүүдэр мэт дагаж ирсэн олон сайн муу үзэгдлийн нэг нь ядуурал түүний үр дагавар юм. Энэ нь нийгмийн амьдралаас урган гарсан олон учиг сэжүүртэй байдаг.

Өнөөдөр дэлхий дахинд нэг тэрбум гаруй хүн голдуу хөгжиж байгаа орнуудад ядуурлын доод түвшинд таван хүн тутмын нэг нь туйлын ядуу зүдүү байдалд амь зууж байна. Ядуурал олон талтай хэцүү асуудал бөгөөд түүний уг язгуур нь үндэсний болон олон улсын шинжтэй байдаг.

Зах зээлд шилжиж буй өнөө үед хүн амын амьжиргааны түвшин эрс доройтож байна. Амьжиргааны түвшний доройтол нь юуны өмнө эдийн засгийн уналттай холбоотой хэдий боловч нийгмийн сэтгэл зүйд сөрөг нөлөө үзүүлдгээрээ ноцтой үзүүлэлт юм. Манай нийгмийн энэ бэрхшээлийг гэтлэн давахын тулд амьжиргааны түвшний бууралт ба ядуурлын талаар аль болох гүнзгийгээр судалж түүнийг гэтлэн давах арга замыг тодорхойлох нэн шаардлагатай байна.

Ядуурал гэдэг нь бага орлого бага хэрэглээ гэсэн үг юм. Нийгмийн энэхүү асуудалд орлогын хомсдол гэсэн нэр томъёоллыг нэлээд түгээмэл хэрэглэж иржээ. Гэхдээ энэхүү ойлголт нь үйлдвэр хөгжсөн чинээлэг умардынхны жишээн дээр үндэслэсэн ойлголт болох нь тодорхой билээ. Харин нүүдэлчний соёл иргэншлийн хэв шинж голлосон хүн ам сийрэг суурьшилтай зах зээлийн багтаамж бага буурай хөгжилтэй манай орны хувьд ядуурал амь зуулгын түвшинг хэрхэн тодорхойлох нь оновчтой болохыг онол, практикийн талаас нарийвчлан судлах шаардлагатай юм.

Монгол дахь ядуурлын шалтгаан

1990 оноос эхлэн Монгол улсын улс төр, эдийн засаг, нийгмийн салбарт эрс өөрчлөлт явагдаж байна. Үүнтэй уялдаад:

1. Монгол улсын зах зээлийн харилцаанд шилжих үйл явц эдийн засгийн гадаад дотоод нөхцөл байдалд үүссэн тааламжгүй өөрчлөлтийн үед явагдаж байгаагаас үүдэн хямрал бэрхшээл тулгарч байна. Монгол улс Төлөрсөн Төлөвлөгөөт Эдийн Засгаас Зах Зээлийн Эдийн Засагт шилжих болсон нь өмнөх тогтолцооны үед олон жилээр хэвшил болж тогтсон нийгмийн хамгаалалтын систем задарч, айл өрх хувь хүмүүсийг нийгмээс дэмжилгэ тусламж үзүүлэх замаар амьдралын түвшинг жигд байлгаж, амьдрах тааламжтай нөхцлийг бүрдүүлж байсныг өөрчлөхөд хүргэсэн.

2. 33ЭЗ-ийн механизм ажиллах нэг гол нөхцөл бол үнэ чөлөөтэй байх явдал юм. Ийм ч учраас манайд бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг дэс дараалалтайгаар чөлөөлсөн. Үнэ чөлөөтэй тогтоодог болсон үед ховор барааны эрэлт нэмэгдэж, үнэ өсдөг зүй тогтлын дагуу хэрэглээний барааны үнийн түвшин өсч, төгрөгийн худалдан авах чадвар уналаа.

3. Хуучин тогтолцооноос 33ЭЗ-ийн тогтолцоонд шилжих шилжилтийн үед монголын эдийн засаг уналтанд орлоо. Эдийн засгийн уналтын үед ажилгүйдэл нэмэгдэх хандлагатай байна. Ажилгүйдэл өссөн нь ядуурлыг нэмэгдүүлэх бас нэг хүчин зүйл боллоо.

Ядуурлын шалтгаан шинж байдал хот, хөдөөд ялгаатай байна. Хотод үйлдвэрлэлийн уналт, ажилгүйдэл өссөнөөс ажлын хөлснөөс өөр амьдралын эх сурвалжгүй хүмүүс орлогын ядууралд орж байна. Мөн эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд байгаль цаг уурын гэнэтийн бэрхшээлээс малчид амьжиргааны гол эх үүсвэр болох малаасаа салж ядуурах нэг нөхцөл болж байна. Хөдөөгийн ядууралд нийгмийн үйлчилгээний хомсдол илүү нөлөөлж байна. Малчид хувийн өмчтэй

олсноор ажиллах хүч дутагдаж, хүүхдээ сургуулиас завсардуулан МАА дээр ажиллуулах үзэгдэл газар авлаа.

Ийнхүү эд хөрөнгийн /орлогын/ ядуурлыг эрдэм соёлын /чадавхийн/ ядуурал дагалдаж, бичиг үсэг үл мэдэх, боловсролгүй хүмүүс олширох хандлага мэдрэгдэж байна.

Ядуурлыг хэмжих

Ядуурлын түвшинг тодорхойлохдоо орлого, хэрэглээг гол үзүүлэлт болгож байна. Нэг хүнд ногдох орлого амьжиргааны доод түвшингээс доогуур орсон үед ядуурал яригдана. Ийнхүү орлогыг үндэс болгон ядуурлыг тогтоохдоо хот, хөдөөд ялгаатай авч үздэг. Хотод болон хөдөөд амьдрагсад нь өдөр тутам хэрэглэж байгаа хоол хүнс, орон сууц, түлш шатахуун, гутал хувцас зэрэг хэрэглээний барааны сагсны бүтцээр ялгаатай учраас амьжиргааны баталгаажих түвшин ялгаатай байна. Амьжиргааны баталгаажих доод түвшинг тогтоохдоо хүн амын амьдралын наад захын хэрэгцээт зүйл болох хоол хүнс, хувцас хунар, орон гэр, ариун цэврийн барааны хэрэглээ зэргийг хүн амын бүлгээр, хот, хөдөөд ялгавартайгаар тооцсон хэрэглээний сагсыг үндэслэдэг.

Нэг хүнд ногдох сарын мөнгөн орлого нь ядуурлын шугамын 40 хувиас бага бол нэн ядуу гэж тооцогддог. Ядуучуудын тоог зөв тогтоохын тулд инфляцын түвшинг харгалзан ядуурлын шугамыг зохистой хугацаанд шинэчлэн тогтоохын зэрэгцээ ядуурлын шугам өөрчлөгдөөгүй байхад ч ядуу өрх, ядуучуудын тоо үнийн өсөлтөөс шалтгаалан нэмэгдэж байдгийг анзаарахгүй өнгөрч болохгүй юм.

Одоо өөрийн орны мэдээг үндэслэн амьжиргааны түвшинг нэг хүний хүнсний бүтээгдэхүүнээс авах илчлэгийн хэмжээгээр тооцож үзье. Амьжиргааны баталгаажих доод түвшинг тооцоход нэг хүний хоногт авах нормын илчлэгийн хэмжээ 2300–2500 ккал байх байтал 1990 оноос эхлэн буурсаар 1994 онд 1815.1 ккал-г хэрэглэсэн байна. Энэхүү илчлэг нь олон нэр төрлийн бүтээгдэхүүнээс тодорхой норм ёсоор бүрдсэн байх ёстой атал дийлэнх хэсэг нь мах, гурил хоёроор илчлэгээ бүрдүүлж байна.

Монгол дахь ядуурлын өнөөгийн байдал

Зах зээлийн өргөтгөсөн харилцаанд шилжих үед монголын нийгэмд байгаа нэг хурц асуудал бол амьжиргааны түвшин буурч ядуурал нэмэгдэх болсон явдал гэдгийг дээр дурдсан билээ. Нийт хүн амын амьжиргааны түвшин буурч байгаа нь эдийн засгийн төдийгүй, соёл боловсрол, эрүүлийг хамгаалах, дэд бүтцийн хөгжлийг хойш татах нэг хүчин зүйл болон хувирч байна.

Нийт ядуу өрхийн ам бүлийн тоо 1994 онд 460,3 мянга, 1995 онд 361,7 мянга байгаагийн 48,76 хувь нь хөдөлмөрийн насны хүн ам, 9,72 хувь нь өндөр настангууд байна. Ядуу өрхийн ам бүлийн 52,1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаагийн зэрэгцээ өрх толгойлсон эмэгтэй 18,3 мянга байгаагийн 7,4 мянга нь нэн ядуу нөхцөлд амьдарч байна. Нийт ядуу өрхийн 22,8 хувь нь эмэгтэй тэргүүлэгчтэй, 25,31 хувь нь 16 хүртэлх насны 4-с дээш хүүхэдтэй, 31,87 хувь нь ажил эрхэлдэг хүнгүй өрх байна. Нийт ядуу өрхийн 50,3 мянган хүн ажил эрхэлж байгаа боловч тэдний үлэмж хэсэг нь тогтвортой ажилгүй, 30,3 хувь нь төсвийн байгууллага, төрийн өмч давамгайлсан аж ахуйн нэгжид ажилладаг тул хөдөлмөрийн хөлсний үнэлгээ болон бодит орлого багатай юм.

Ядуу өрхийн ам бүлээс хөдөлмөрийн насны ажилгүй хүн 59,6 мянга буюу 40,9 хувь, нэн ядуу өрхийн ам бүлээс 25,3 мянга буюу 44,7 хувь байгаа нь ажилгүйдлийг арилгах, хувиараа аж ахуй эрхлэх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Ядуу амьдралтай хүмүүсийн ерөнхий байдлыг авч үзвэл ам бүл олонтой, аминдаа малгүй буюу цөөн малтай, ажиллах чадваргүй юм уу эсвэл ажиллах чадвартай боловч ажилгүйн улмаас хүнс тэжээл бусад хэрэгцээт зүйлээ худалдаж авах чадваргүй хүмүүс юм. Ядуу хүмүүст дээр дурдсан шинж чанар бүхий амьдралтай

хүмүүс голчлон хамаарагдаж байгаагаас гадна тахир дутуу, өвчний улмаас харах, сонсох боломжгүй иргэд, хэвтрийн өвчтэй иргэд хамаарагдаж байна.

Монголын хүн амын амьжиргааны байдал

Манай оронд амьжиргааны түвшинг тодорхойлохдоо өрхийн төсвийн судалгааг үндэслэдэгийг дээр дурдсан билээ. Өрхийн төсвийн судалгааг үндэслэн 1995 оны амьжиргааны байдлын талаар танилцуулъя:

Өрхийн аж ахуйн судалгаа болон статистикийн бусад тайлан, судалгаанаас үзэхэд хүн амын амьжиргааны түвшин нь өрхийн ам бүлийн тоо, тэдгээрийн ажил эрхлэлтийн байдалтай шууд хамааралтай байдаг. Өрхийн ам бүл, тэдгээрээс ажил хөдөлмөр хийж орлого олдог хүний тоо өөрөөр хэлбэл, нэг тэжээгчид ногдох тэжээлгэгчийн тооноос тухайн өрхийн амьжиргааны түвшин ямар байх нь шууд хамаардаг. Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан нийт өрхүүдийн дундаж ам бүл хотод 4.7, хөдөөд 4.9 хүн байхад ядуу өрхийн ам бүл хотод 5.5, хөдөөд 6.2 хүн байна. Гэтэл амьжиргааны баталгаажих доод түвшингээс дээгүүр орлоготой өрхүүдийн дундаж ам бүл хотод 4.1, хөдөөд 4.8 хүн байгаа юм.


Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан хотын ядуу өрхийн хөдөлмөрийн насны нийт хүн амын 38.5 хувь нь, хөдөөд 37 хувь нь ажилладаг байхад бусад өрхөд хотод 54.2 хувь, хөдөөд 58.3 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Тодруулбал: энэ нь ядуу өрхийн ажил эрхэлдэг нэг хүн өөрөөсөө гадна 4-5 хүнийг тэжээн тэтгэж байхад бусад өрхөд дунджаар 3 хүнийг тэжээн тэтгэж байгаа юм.

Ядуу өрхийн жилийн дундаж мөнгөн орлого нь хотод 289.4 мянган төгрөг, хөдөөд 202.6 мянган төгрөг байхад бусад өрхөд хотод 600.7 мянган төгрөг, хөдөөд 417.9 мянган төгрөг байгаа нь ядуу өрхийнхөөс 2 дахин илүү байна.

Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан ядуу өрхийн мөнгөн орлогод цалингийн эзлэх хувийн жин 57.6 хувь, тэтгэвэр тэтгэмж 12.6 хувь, бусад өрхийн хувьд цалин хөлс 48.5 хувь тэтгэвэр тэтгэмж 5.1, арилжаа наймааных 16.5 хувийг эзэлж байна. Эндээс харахад ядуу өрхийг бодвол бусад өрхүүд арилжаа наймааны бусад төрлийн орлогоороо илүү байна.

Хөдөөгийн өрхүүдийн орлогын гол эх үүсвэр нь мал, ХАА-н бүтээгдэхүүний борлуулалтын болон арилжаа наймааны орлогоос бүрдэж байгаа ерөнхий зүй тогтол ядуу өрхөд мөн адил байна. Хөдөөгийн ядуу өрхийн орлогод мал, ХАА-н бүтээгдэхүүний борлуулалт, арилжаа наймааны орлогын эзлэх хувийн жин 26.7 хувь байхад энэ үзүүлэлт бусад өрхөд 35.3 хувийг эзэлж байна. (График 1, График 2)


График 1



- 1 Цалин хөлс
- 2 Тэтгэвэр тэтгэмж
- 3 Мал,ХАА-Н бүтээгдэхүүн
- 4 Борлуулсаны орлого
- 5 ХАА-н бус бүтээгдэхүүний
- 6 Борлуулалтын орлого

- 7 Үйлчилгээний орлого
- 8 Арилжаа наймааны орлого
- 9 Түрээсийн
- 10 Тусламж нөхвөр
- 11 Зээл
- 12 Бусад орлого

График 2




Үзүүлэлтүүдийн тайлбарыг график1-ээс

Одоо мөнгөн зарлагын бүтцийг авч үзье. Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан өрхүүдийн мөнгөн зарлагад дундажаар хүнсний зүйлийн зарлага 1995 онд хотод 51.3 хувь, хөдөөд 42.8 хувийг эзэлж байхад ядуу өрхөд энэ үзүүлэлт хотод 63.6 хувь, хөдөөд 43.0 хувь байна. Харин бусад өрхөд дээрх үзүүлэлт хотод 45.8 хувь, хөдөөд 39,1 хувийг эзэлж байна.

Үүнээс үзэхэд ядуу өрх мөнгөн орлогынхоо дийлэнх хэсгийг хүнсэнд хэрэглэж, бусад төрлийн барааг худалдан авах боломж хомс байна. (График 3, График 4)


График 3



- 1 Хүнсний зүйлийн
- 2 Хүнсний бус зүйлийн
- 3 Таваарын бус мөнгөн зарлага
- 4 Хадгаламж

График 4

Хөдөөгийн өрхийн мөнгөн зарлага



Үзүүлэлтүүдийн тайлбарыг график 3-аас
Мэдээллийн эх үүсвэр: Өрхийн төсвийн судалгаа 1995 он

Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан өрхүүд дунджаар хүнсний зүйлийн мөнгөн зарлагад мах, махан бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 28.9, хөдөөд 4.7 байгаа бол ядуу өрхөд энэ үзүүлэлт хотод 31.0 хувь, хөдөөд 7.7 хувь байна. Хөдөөд энэ хувь бага байгаа нь мах, махан бүтээгдэхүүнийг ихэвчлэн өөрийн аж ахуйгаас шууд хэрэглэж, мөнгө бага зарцуулж байгаатай холбоотой.

Ядуу өрхийн хүнсний мөнгөн зарлагад гурил гурилан бүтээгдэхүүний эзлэх хувь хотод 35.0, хөдөөд 61.6 байна. Амьжиргааны баталгаажих доод түвшингээс дээгүүр орлоготой бусад өрхөд хүнсний бүтээгдэхүүний мөнгөн зарлагад мах, гурилан бүтээгдэхүүний эзлэх хувийн жин ядуу өрхийнхөөс доогуур бусад бүх бүтээгдэхүүнийх өндөр байна. Энэ нь монголын хүн ам хүнсэндээ мах, гурилан бүтээгдэхүүн голлон хэрэглэж байгаагийн дотор ядуучуудад мах, гурилаас өөр төрөл бүрийн амин дэмтэй хүнсний бүтээгдэхүүний хэрэглээ маш дутмаг байна.

Өрхийн нэг ам бүлийн хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүнийг үндэслэн тооцвол хотын ядуу өрхийн нэг гишүүн хоногт 1781 ккал, бусад өрхөд 2783 ккал, хөдөөний ядуу өрхийн нэг гишүүн 1828, бусад өрхөд 3149 ккал илчлэгтэй хүнсний бүтээгдэхүүн хэрэглэж байна. Өрхийн нэг ам бүлд хоногт хэрэглэсэн илчлэг 1995 онд өнгөрсөн жилийнхээсээ ядуу өрхөд 279–413 ккал, бусад өрхөд 673–987 ккалаар нэмэгдсэн байна. Өрхийн нэг хүнд ногдох хүнсний зүйлийн биет хэрэглээ өнгөрсөн жилийнхээс махнаас бусад бүтээгдэхүүнд нэмэгдсэн нь хоногт хэрэглэсэн хүнсний бүтээгдэхүүний илчлэгийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлсэн байна. Өрхийн нэг ам бүлд ногдох махны хэрэглээ 1995 онд 1994 оныхоос хотын ядуу өрхөд 22.1 кг-аар, хөдөөгийнхэнд 31.4 кг-аар буурсан байна.

Хотын ядуу өрх хүнсний бус бараа, бүтээгдэхүүн худалдаж авсан мөнгөн зарлагынхаа 46.0 хувийг бэлэн хувцас, гутал ботинк худалдаж авахад зарцуулжээ. Харин хотын ядуу өрхийн эм, эрүүл ахуйн бараа бүтээгдэхүүн худалдаж авсан мөнгөн зарлага нийт зарлагын 16.5 хувийг эзэлж байхад энэ үзүүлэлт бусад өрхөд 9.5 хувь байгаа нь хот суурин газарт амьдардаг ядуу өрхийн хоол хүнсний хүрэлцээ, эрүүл ахуйн нөхцөл хүнд байдгаас өвчлөх нь бусад өрхөөс илүү байдагтай холбоотой юм. Нөгөө талаар хотын ядуу өрхөд хүнсний бус бараа, бүтээгдэхүүний нийт зардлын дотор түлшний зардал 15.5 хувийг эзэлж байгаа нь нэлээд өндөр үзүүлэлт юм.

Хөдөөгийн ядуу өрхөд бөс бараа, гутал хувцасны зардал нэлээд өндөр хувьтай байгаа боловч эм, эрүүл ахуйн зардал нэлээд өндөр хувьтай байна. Эдгээрээс үзэхэд өвчлөл ядуу өрхийн дотор өндөр, хүрэлцээгүй байгаа орлогынхоо тодорхой хувийг эм, тариа авахад зарцуулж, хоол хүнс бусад зайлшгүй хэрэгцээт бараа бүтээгдэхүүний хомсдолд орсоор байна.

Хотын ядуу өрхийн таваарын бус мөнгөн зарлагад орон сууц нийтийн аж ахуйн зардал 44.3 хувь, тээвэр, холбооны зардал 14.8 хувь, төрөл бүрийн татвар хураамжийн төлбөр 6.9 хувь, сургалтын болон эрүүл мэндийн төлбөр 9.0 хувийг эзэлж байна.

Зах зээлийн эдийн засгийн харилцааны энэ үед манай хүн амын амьжиргаанд баян,хоосны ялгаа гарч байгаа нь өрхийн аж ахуйн судалгааны сүүлийн жилүүдийн дүнгээс харагдаж байна. Сард нэг хүнд ногдох орлогоороо хамгийн доод бүлгийн (1951 хүртэл төгрөг) өрхүүдийн дунджаар нэг хүнд ногдох жилийн мөнгөн орлого нь 13.8 мянган төгрөг, нийт орлого нь 17.6 мянган төгрөг байхад хамгийн дээд бүлгийн (18451-ээс дээш төгрөгийн) өрхүүдийн дунджаар нэг хүнд ногдох жилийн мөнгөн орлого 270.8 мянган төгрөг, нийт орлого нь 341.2 мянган төгрөг байгаа нь ядуу өрхийнхөөс 18 дахин өндөр байна. Орлого нь ийнхүү ялгаатай байгаатай уялдан зарлага, хэрэглээний бүтэц ихээхэн зөрүүтэй байна.

Өрхийн аж ахуйн судалгаанд хамрагдсан өрхүүдийн дунджаар жилийн нийт орлого 525.9 мянган төгрөг, мөнгөн орлого нь 405.7 мянган төгрөг байгаатай зэрэгцүүлэхэд орлогын хамгийн бага бүлэгт багтах өрхүүдийн дундаж орлого улсын дунджаас 3.7 дахин бага байхад, орлогын хамгийн өндөр бүлэгт багтах өрхүүдийнх 2 дахин өндөр байна.

Ядуурал нь хүн амын бодит орлого, амьжиргааны түвшин буурснаар илэрч байгаа төдийгүй, хоол тэжээлийн илчлэг дутагдсанаас эрүүл мэнд муудах, боловсрол, соёлын салбарын үйл ажиллагаа хямарч оюуны хоосролд орох, хүүхэд сургууль завсардах, тэнүүчлэх, нийгэм ёс суртахууны доройтолд орж, гэр бүл салах, хүүхэд өнчрөх,гэмт хэрэг өсөх зэрэг ноцтой сөрөг үр дагаваруудийг дамжруулж байна.

Тэрчлэн ажилгүйдэл, хагас ажилгүйдэл нэмэгдэж буй нь хөдөлмөрийн нөөцийг бүрэн ашиглаж, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ихээхэн боломжийг алдаж байна. Хэрэв ядуурлын одоогийн түвшин хэвээр байх буюу цаашид нэмэгдвэл зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үйл явц удааширч, өөрчлөлт, шинэчлэлтийн өргөн цар хүрээтэй бодлого, үйл ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй юм.

Ийнхүү ядуурал бий болох үндсийг арилгах, ядуурлыг бууруулах, ядуурлаас гарах оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага хурцаар тавигдаж байна.

Ядуурлыг бууруулах өргөн хүрээтэй, иж бүрэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хөрөнгө санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй байгаа нь гол бэрхшээл юм. Тухайлбал: Жижиг, дунд үйлдвэрүүдийг байгуулахад хөрөнгө нөөц дутагдалтай, хөдөө орон нутгийн дэд бүтцийн хөгжил муугаас үйлдвэрлэл хөгжүүлэх, зах зээлийн харилцаанд оролцох боломж бага, аймаг, сумдад бараа материалын эрэлт, хэрэгцээ, үнэ болон худалдаа, аж ахуй эрхлэх талаар мэдлэг, мэдээлэл авах боломж харьцангуй бага байна.

Ийнхүү Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж буй анхны үе шатанд хүнс, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тариф өсч, мөнгөний ханш унаж, ажилгүйдэл нэмэгдэн, хөдөлмөрийн үнэлэмж, хүн амын бодит орлого буурч, амьжиргааны түвшин доройтон ядуу болон нэн ядуу амьдралтай айл өрх, түүний тоо улам бүр нэмэгдэх хандлагатай боллоо. Нэн ялангуяа ядуурал хот суурин газар төвлөрөх хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. 1992 онд явуулсан улсын үзлэгийн дүнгээр нийт ядуу өрхийн 52,1 хувь, нэн ядуу өрхийн 53,7 хувь нь хот аймгийн төвд амьдарч байна. Үүнтэй уялдуулан ядуурлыг бууруулах арга хэмжээг хот суурин газар төвлөрүүлэх, гэхдээ тэнд анхаарлыг хандуулах ёстой гээд хөрөнгө мөнгийг хүн ам олон суурьшсан нийслэл рүү хуваарилаад байвал монголын хөдөө эзгүйрч төв рүү чиглэсэн их нүүдэл үүсч, давхар давхар ачаалал нэмэгдэж, бэрхшээлтэй зүйл ихсэж болохыг бодолцох хэрэгтэй.

Ядуурлыг бууруулах гол зорилтын нэг нь зээл тусламж олгохдоо гол бус ядуучуудаар ажил хийлгэх замаар орлогын байнгын эх үүсвэртэй болгох явдал юм. Сүүлийн жилүүдэд тухайн иргэний амьдрах чадвар нууц орлогыг үндэс болгон ядууралд зориулсан тусламжийг бий болгож байгаа нь социализмын бэлэнчлэх сэтгэлгээнээс олон улсын зээл тусламж, хоол хүнсэнд бишрэх сэтгэлгээнд шилжихэд түлхэц өгч байна. Иймд ядуу болон нэн ядуу өрхийг нарийн үзүүлэлтээр судлан тогтоож ялгавартай хандах нь чухал юм.

Өрх, хүн амын бүртгэл ялангуяа өрхийн орлогыг зөв бүртгэх өөрөөр хэлбэл, манай орны хувьд орлого тодорхойлох нэгдсэн механизмтай болох арга хэмжээ авах хэрэгтэй байна. Үнэндээ ядуучуудын дунд судалгаа явуулж жинхэнэ өөрсдийнх нь бодол, санал, байдлыг нарийн танилцсан зүйл хомс байгаа учраас тэдний гүнд орж ажиллаж, судалгаа явуулж, тэдний өөрсдийнх нь тусламжтайгаар ядуурлаас гарах арга замыг тодорхойлох нь чухал юм.

Ядуурлыг бууруулах талаар төр, захиргаа, хууль хяналтын байгууллагууд тус тусын чиглэлээр идэвхтэй ажиллах, тэрчлэн энэ талаар хувь хүн бүр санаачлагатай ажиллах шаардлагатай байна.

Ашигласан материал

Ажилгүйдэл, ядуурлын байдалд явуулсан улсын үзлэгийн дүн, 1995 он

ЗГ-с тогтоосон амьжиргааны түвшинг тооцох аргачилсан зөвлөмж, УБ, 1994 он

"Монгол дахь ядуурал" Д/док Д/проф Б. Сувд

Хүн амын амьжиргааны байдлын 1995 оны танилцуулга, УСГ

Ядуу өрх, ам бүлийн тайлан он УСГ, 1993, 1994, 1995

"Ядуурал, амь зуулгыг тойрсон яриа" П.Бямбацэрэн

"Монгол тамга", УБ 1996

"Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр", УБ, 1995 он